



ДУНДГОВЬ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 5/06

Мандалговь

А.Ганзаяад хүүхэд асрах чөлөө олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч Алтангэрэлийн Ганзаяа нь хүүхэд асрах чөлөөний хүсэлт гаргасан тул 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хүүхэд асрах чөлөө олгосугай.

2. А.Ганзаяагийн хүүхэд асрах чөлөөний хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон төлж байхыг нягтлан бодогч (Н.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасаг (Ш.Мөнгөнцэцэг)-т даалгасугай.

ДАРГА *Ш.Мөнгөнцэцэг* М.ТУЯАЦЭЦЭГ

